



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/198

Улаанбаатар хот

┌ Журам шинэчлэн батлах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийг 26.1.2, Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 2019 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалтын 11, 16, 24, 37, 48, 49 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Зам, тээврийн салбарын албан хаагчид шагнал олгох журам”-ыг нэгдүгээр, “Засгийн газрын хүндэт тэмдэг”-ийн ерөнхий загварыг хоёрдугаар, “Зам, тээврийн хөгжлийн яамны “Хүндэт жуух бичиг”-ийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Шагналын үнэмлэх, гэрчилгээ, тэмдэг хэвлүүлэх болон холбогдох бусад зардлыг байгууллагынхаа төсөвт төлөвлөж, зарцуулахыг харьяа агентлаг, байгууллагын дарга (захирал) нарт зөвшөөрсүгэй.

3. Журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Зам, тээврийн салбар байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Ц.Одхүү)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2020 оны А/50 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

080000543

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны
07 дугаар сарын 19 өдрийн 47/2023 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын зам, тээврийн салбарыг хөгжүүлэхэд үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, онцгой амжилт гаргасан албан хаагч, Монгол Улсын болон гадаадын иргэнийг Засгийн газрын /цаашид "салбарын шагнал" гэх/ болон Зам, тээврийн хөгжлийн яамны шагнал /цаашид "яамны шагнал" гэх/-д нэр дэвшүүлэх, шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Засгийн газрын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. "Автотээврийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг,

2.1.2. "Хүндэт төмөр замчин" хүндэт тэмдэг,

2.1.3. "Тэргүүний замчин" хүндэт тэмдэг,

2.1.4. "Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг,

2.1.5. "Усан зам, далайн салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг,

2.1.6. "Онц тээвэрчин" хүндэт тэмдэг.

2.2. Зам, тээврийн хөгжлийн яамны шагнал нь дор дурсан төрөл байна.

2.2.1. Яамны "Хүндэт жуух бичиг".

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Зам, тээврийн салбарын шагналыг яам, Засгийн газрын гэсэн дарааллаар дор дурдсан үзүүлэлтийг хангасан албан хаагч, иргэнд олгоно. Үүнд:

3.1.1. Зам, тээврийн салбарын ажил, үйлчилгээг боловсронгуй болгох дэвшилтэт техник, технологи, шилдэг арга ажиллагаа нэвтрүүлэн ажил үйлчилгээний чанар, нэр төрөл, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлсэн тодорхой үр дүн, үр бүтээл гаргасан;

3.1.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулсан, салбарын хөгжилд онцгой үр дүн өгөхүйц эрдэм шинжилгээ, судалгааны шинэ нээлт, бүтээл туурвисан;

3.1.3. Зам, тээврийн салбарт онцгой амжилт гаргасан, оновчтой санаачилга гаргасан, тодорхой үр дүн бүхий бүтээлч ажил хийсэн. (энэ тохиолдолд онцгой амжилт гаргасныг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар);

3.1.4. Салбартаа амжилт гарган тогтвортой ажиллаж, амжилт бүтээл нь хамт олон, үйлчлүүлэгч, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэжлийн өндөр ур чадвар, туршлагатай;

3.1.5. Байгууллагын соёл, үнэт зүйлийг эрхэмлэн, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэхэд үлгэрлэгч байх;

3.2. Засгийн газрын шагналыг Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т заасан шаардлагын дагуу дараах байдлаар олгоно. Үүнд:

3.2.1. Автотээврийн салбарт 12-оос доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан, журмын 3.1, 3.2-т заасан болзол, шаардлагыг хангасан автотээврийн инженер, техник, үйлчилгээний ажилтныг "Автотээврийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр;

3.2.2. Төмөр замын тээврийн салбарт 12-оос доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан, журмын 3.1, 3.2-т заасан болзол, шаардлагыг хангасан албан хаагч, иргэнийг "Хүндэт төмөр замчин" хүндэт тэмдгээр;

3.2.3. Авто замын салбарт 12-оос доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан, журмын 3.1, 3.2-т заасан болзол, шаардлагыг хангасан инженер, техникч, замчин, механизмчныг "Тэргүүний замчин" хүндэт тэмдгээр;

3.2.4. Иргэний агаарын тээврийн салбарт 12-оос доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан, журмын 3.1, 3.2-т заасан болзол, шаардлагыг хангасан албан хаагч, иргэнийг "Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр;

3.2.5. Усан зам, далайн тээврийн салбарт 12-оос доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан, журмын 3.1, 3.2-т заасан болзол, шаардлагыг хангасан албан хаагч, иргэнийг "Усан зам, далайн салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр;

3.2.6. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээврийн ажил үйлчилгээ эрхэлдэг мэргэжлээр 12-оос доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан, журмын 3.1, 3.2-т заасан болзол, шаардлагыг хангасан жолоочийг "Онц тээвэрчин" хүндэт тэмдгээр;

3.3. Улсад 10 жил, зам, тээврийн салбарт 5 болон түүнээс дээш жил идэвх зүтгэлтэй ажилласан, тухайн байгууллагад 3 жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч, иргэнийг яамны "Хүндэт жуух бичиг"-ээр шагнаж урамшуулна.

3.4. Шагналыг Үндэсний их баяр наадам, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баяр, Цагаан сарын баяр, тухайн салбарын 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тэгш ой болон салбарын дор дурдсан тэмдэглэлт өдрийг тохиолдуулан олгоно.

3.4.1. Иргэний агаарын тээвэрчдийн өдөр; (жил бүрийн 5 дугаар сарын



4 дэх Ням гараг);

3.4.2. Авто тээвэрчдийн өдөр; (жил бүрийн 7 дугаар сарын 3 дахь Ням гараг);

3.4.3. Төмөр замчдын өдөр-(жил бүрийн 8 дугаар сарын эхний Ням гараг);

3.4.4. Авто замчдын өдөр-(жил бүрийн 10 дугаар сарын 4 дэх Ням гараг);

3.4.5. Усан зам, далайн тээвэрчдийн өдөр-(жил бүрийн 08 дугаар сарын 20-ны өдөр);

3.5. Зам, тээврийн хөгжлийн яамны “Хүндэт жуух бичиг”-ийг энэхүү журмын 3.4-т заасан өдөр олгоно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа зам, тээврийн салбарын албан хаагч, тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтныг үндсэн байгууллага нь шагналд тодорхойлно.

4.2. Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллагуудын салбар нэгжүүдээс шагналд тодорхойлохдоо зөвхөн үндсэн байгууллагаар дамжуулан, тухайн харьяа байгууллагын дарга, захирал нар тодорхойлно.

4.3. Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бусад олон нийтийн байгууллагаас зам, тээврийн салбарын албан хаагчийг шагнуулах санал дэвшүүлсэн тохиолдолд тухайн албан хаагчийн ажиллаж байгаа байгууллагаас заавал санал авсан байна.

4.3. Салбарын болон яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэгч байгууллага нь шагналын цахим бүртгэлийн системд бүртгүүлэх хүсэлтээ “ХУР” систем, байгууллагын мэдээлэл солилцооны системүүдийг ашиглаж, эсвэл яамны шагнал хариуцсан мэргэжилтэнтэй холбогдож баталгаажуулалт заавал хийлгэнэ.

4.4. Салбарын болон яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэгч байгууллага нь шагналд нэр дэвшүүлсэн албан хаагч, иргэний материалыг журмын 3.3-т заасан баяр, тэмдэглэлт өдрөөс 30 хоногийн өмнө яамны шагналын цахим бүртгэлийн систем ([mrttd.gov.mn/салбарын шагнал](http://mrttd.gov.mn/салбарын_шагнал))-д баталгаажсан хэрэглэгчийн эрхээрээ үнэн, зөв ирүүлсэн байна.

4.5. Шагналын цахим бүртгэлийн систем нь тухайн баяр, ой, тэмдэглэлт өдөр болохоос 90 хоногийн өмнө нээгдэж 30 хоногийн өмнө хаагдах ба энэ хугацаанд хүсэлт гаргагч байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нь цахим бүртгэлийн системд хандаж шагналд нэр дэвшигчдийн хүсэлтийн төлөвийг шалгана.

4.6. Засгийн газрын болон яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ.

4.6.1. Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг;

4.6.2. Зам, тээврийн салбарын шагналын журмын хавсралтаар баталсан загвар анкетыг үнэн зөв бөглөсөн байна.



4.6.3. Хамт олны эсхүл удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл

4.6.4. Ажил байдлын дэлгэрэнгүй тодорхойлолт /ажлын үр дүнгийн үзүүлэлт, бүтээлийн жагсаалтыг хавсаргах/;

4.6.5. Яамны болон төр засгийн бусад шагналаар шагнагдсан бол тэдгээрийн хуулбар;

4.6.6. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар;

4.6.7. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар (зөвхөн нүүр, ажилд авсан болон чөлөөлсөн хэсэг)

4.7. Шагналд нэр дэвшүүлэхдээ өмнө шагнагдсан яам болон Засгийн газрын шагналаас хойш 3-аас доошгүй жил тухайн салбартаа тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс өссөн эсэхийг харгалзана.

4.8. Энэхүү журмын 3.1.3-т заасан үзүүлэлтээр шагнагдах хүмүүст ажилласан жилийг харгалзахгүй.

4.9. Энэхүү журмын 2.1.1, 2.1.6-д заасан шагналд нэр дэвшигч өмнө нь Засгийн газрын “Автотээврийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг болон “Онц тээвэрчин” хүндэт тэмдгийн аль нэгээр шагнагдсан бол давхардуулан олгохгүй.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Зам, тээврийн хөгжлийн яамны шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн цахимаар шагналын материалыг хүлээн авч хянана.

5.2. Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэхүү журмын 3.1, 3.2-т заасан болзол шаардлагыг хангасан эсэх талаар санал боловсруулан Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга нарт танилцуулна.

5.3. Шагнах асуудлыг Сайдын тушаал гаргаж шийдвэрлэнэ.

5.4. “Автотээврийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Хүндэт төмөр замчин” хүндэт тэмдэг, “Тэргүүний замчин” хүндэт тэмдэг, “Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Усан зам, далайн салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Онц тээвэрчин” хүндэт тэмдэг, “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдагчдад хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.

5.5. Шагнагдсан хүмүүсийн мэдээллийг цахим бүртгэлийн системд байршуулах бөгөөд шагналын тэмдэг, үнэмлэхийг тодорхойлсон байгууллагад хүлээлгэн өгнө.

5.6. Шагналд нэр дэвшигчийн холбогдох мэдээллийг вэб программд хуурамчаар бүртгүүлсэн нь нотлогдсон тохиолдолд тухайн иргэний регистрийн дугаараар мэдээлэл оруулах эрхийг 3 жилийн, байгууллагын эрхийг 1 жилийн хугацаанд хаана.

5.7. Журмын 3.1-д заасан болзол шаардлагыг хангаагүй, баримт бичгийг 4.4-д заасны дагуу цахим бүртгэлийн системд бүртгэлгүй албан хаагч, иргэнд шагнал олгохгүй.



5.8. Шагналын материалыг дараах онцгой тохиолдолд цаасаар хүлээн авна.
Үүнд:

5.8.1. Программын серверийн үйл ажиллагаа зогсох, гадны нөлөөлөл, программ хангамжийн эвдрэлийн улмаас программд хандалт хийх боломжгүй болох;

5.8.2. Яаралтай буюу программ хангамжийн хэт их ачаалалтай үед материалыг цаасаар хүлээн авч вэб программд оруулж болно.

Зургаа. Тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгох

6.1. Шагналын тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсний улмаас нөхөн авах тохиолдолд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж яаманд ирүүлнэ.

6.1.1. Өргөдөл/албан бичиг

6.1.2. Иргэний үнэмлэхний хуулбар;

6.1.3. Шагналын үнэмлэхний хуулбар;

6.1.4. Мөнгө тушаасан баримт;

6.1.5. Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн өргөдлийг хянан үзээд хүндэт тэмдэг, үнэмлэх, "Жуух бичиг"-ийг нөхөн олгох үндэслэлтэй гэж үзвэл хэвлүүлсэн зардлыг холбогдох байгууллага, иргэнээс гаргуулсны дараа олгоно.

Долоо. Шагналын мэдээллийн сан

7.1. Яам нь шагнагдсан хүмүүсийн цахим мэдээллийн сантай байна. Санг шагналын төрлөөр, он дарааллаар төрөлжүүлэн бүрдүүлнэ.

7.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан, хяналт тавина.

7.3. Төрийн албан хаагч Монгол Улсын цол, төрийн дээд одон, медаль болон энэ журамд заасан шагналаар шагнуулсан бол энэ тухай мэдээллийг Төрийн албаны тухай хуулийн 15.1-д заасны дагуу тухайн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж хадгална.

Найм. Бусад зүйл

8.1. Зам, тээврийн хөгжлийн яамны ажилтнуудаас тэмдэглэлт өдөр, ойг тохиолдуулан төрийн дээд, цол одон, медаль, хүндэт өргөмжлөлөөр шагнуулахаар тухайн газраас дэвшүүлсэн албан хаагчийн материал, хурлын тэмдэглэлийг Төрийн захиргааны удирдлагын газраас судлан үзэж шаардлага хангасан бол Төрийн нарийн бичгийн дарга, сайдад танилцуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан "Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам"-д заасны дагуу нэр дэвшүүлэн, уламжилж, цахим санд бүртгэн өргөн мэдүүлнэ.



Зам, тээврийн салбарын шагналын
журмын нэгдүгээр хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ШАГНАЛААР ШАГНАГДАХ ИРГЭНИЙ АНКЕТ

/заавар/

1. Овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр
2. Регистрийн дугаар
3. Хүйс
4. Боловсрол
5. Мэргэжил
6. Үндсэн захиргаа
7. Ажилладаг салбар

Зураг 4x6

8. Урьд болон одоо ажиллаж байгаа газар

№	Ажлын газрын нэр	Эрхэлсэн ажил	Хугацаа
Нийт ажилласан жил			

9. Төр, Засгийн болон бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан:

№	Шагналын нэр	Шагнагдсан он /заавал бичнэ/

10. Шагнуулах гэж байгаа үндэслэл /тухайн хүний ажлын амжилт, гаргасан үр дүн, туурвисан бүтээл зэргийг сүүлийн 5 жилээр тодорхой бичиж, шаардлагатай гэж үзвэл холбогдох жагсаалтыг хавсаргана/

.....
.....



.....
.....
.....

11. Ямар шагналаар шагуулах:

.....
.....
.....

12. Хамт олны саналын хувь:

.....
.....

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА /ЗАХИРАЛ/ -ЫН ГАРЫН ҮСЭГ,
ТАМГА / ТЭМДЭГ



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны
07 дугаар сарын 19 өдрийн 1198 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ ЗАМ, ТЭЭВРИЙН
САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН /"АВТОТЭЭВРИЙН ТЭРГҮҮНИЙ
АЖИЛТАН", "ХҮНДЭТ ТӨМӨР ЗАМЧИН", "ТЭРГҮҮНИЙ ЗАМЧИН", "ИРГЭНИЙ
АГААРЫН ТЭЭВРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН", "УСАН ЗАМ, ДАЛАЙН
САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН", "ОНЦ ТЭЭВЭРЧИН"
ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЕРӨНХИЙ ЗАГВАР

"Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг нь тухайн салбар, ажил, мэргэжлийн чиглэл, онцлогийг бэлгэдсэн дүрслэлтэй, тэмдгийн оноосон нэрийг бичсэн, дээд хэсэгт соёмбо дүрсэлсэн, урт нь 40-45 мм, өргөн нь 20-22 мм, зузаан нь 2,5 мм-ээс илүүгүй хэмжээтэй байна.

___оОо___

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны
07 дугаар сарын 19 өдрийн А/198 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
"ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ"-ИЙН ЗАГВАР**

Яамны "Хүндэт жуух бичиг" нь дараах техникийн тодорхойлолтыг хангасан байна. Үүнд:

"Хүндэт жуух бичиг нь 297x210мм хэмжээтэй хуудсыг А5 хэмжээгээр 2 нүүрт хуваан, тус бүр түмэн насан хээгээр дэвсгэрлэсэн, 10 мм өргөн алхан хээгээр хүрээлсэн байна.

Нэгдүгээр нүүрэнд хоёрдугаар нүүрт бичигдсэн бичвэрийг монгол бичгээр хөрвүүлэн бичих бөгөөд дугаар, он, тушаалын дугаарыг бичихгүй байж болно.

Хоёрдугаар нүүрэнд дээд хүрээнээс доош 15 мм зайд 25x25 мм хэмжээтэй соёмбо бүхий Зам, тээврийн хөгжлийн яамны лого байх ба соёмбоос доош 1 мм зайд голлуулан "Дугаар....." гэж бичсэн байна. Түүнээс доор 15 мм зайд "Хүндэт нөхөр.....Танаа" гэсэн үгийг байрлуулна. Түүний доор 2 мм зайд "Монгол Улсын Зам, тээврийн салбарыг хөгжүүлэхэд Таны оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж яамны "ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ"-ээр шагнав." гэсэн өгүүлбэрийг бичсэн байна.

Уг өгүүлбэрээс доош 3 мм зайд "МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД(нэр) байна.

Мөн 2 дугаар нүүрний доод хүрээнээс 10мм зайд "20....оны-р тушаал, Улаанбаатар хот" гэсэн бичвэрийг голлуулан бичнэ.

"ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ" гэсэн бичвэр улаан өнгөөр, бусад бүх бичвэр хар өнгөтэй байна.

_____оОо_____